



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар A/380

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хурдан морь унаач хүүхдийн стандартын хамгаалалтын иж бүрэн хувцас, хэрэглэлийг жишиг болгож хэвшүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй хамгаалалтын хувцас худалдан авах зардалд 9390 000 төгрөгнөөс 50 хувийг хөнгөлж 4 695 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 4695 000 төгрөг / Дөрвөн сая зургаан зуун ерэн таван мянган /-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ

